




I. ХПВ-ТЭЙ ХОЛБООТОЙ ЕРӨНХИЙ АСУУЛТУУД



ХПВ ГЭЖ ЮУ ВЭ?

ХПВ нь Хүний Папиллома Вирусийн товчлол юм. Одоогоор ХПВ-ийн 200 гаруй хэв шинж бүртгэгдсэнээс хавдар үүсгэх эрсдэл өндөртэй, багатай гэж 2 бүлэгт ангилагддаг. ХПВ-ийн халдвар ихэнхдээ шинж тэмдэггүй байдаг.

ХПВ-ИЙН ХАЛДВАР ХЭРХЭН ДАМЖДАГ ВЭ?

ХПВ нь дараах замаар халдварлана. Үүнд:

1. Бэлгийн замаар
2. Аман болон анал хавьтлаар
3. Төрөх замаар (төрөх үед эхээс хүүхдэд халдвар дамжих эрсдэлтэй)

ХПВ-ИЙН ХАЛДВАР ТҮГЭЭМЭЛ ҮҮ?

Тийм. 10 эмэгтэй, 8 эрэгтэй хүн тутмын 1 нь амьдралынхаа туршид ХПВ-ийн халдварын нэг болон түүнээс дээш хэв шинжийн халдвар авдаг.

Халдварт өртөх 2 оргил үе байдаг:

- 25-аас доош насанд
- 45-аас дээш насанд

ХПВ ӨВЧИН ҮҮСГЭХ ЭРСДЭЛТЭЙ ЮУ?

Тийм. Энэ вирусийн өндөр эрсдэлтэй 12 хэв шинж нь умайн хүзүү, ам залгиур, хошног, шодой, гадна бэлэг эрхтэн, үтрээний хавдар зэрэг 6 төрлийн хорт хавдар үүсгэх эрсдэлтэй бөгөөд умайн хүзүүний хавдрын 100%, хошногны хавдрын 88%, үтрээний хавдрын 78%, шодойн хавдрын 50%, ам залгиурын хавдрын 30%, гадна бэлэг эрхтэний хавдрын 25%-ийн шалтгаан болдог.

Өндөр эрсдэлтэй ХПВ-ийн 16 болон 18-р хэв шинжүүд нь умайн хүзүүний хавдрын 10 тохиолдлын 7-г үүсгэдэг. ХПВ-ийн халдвар авсан эмэгтэйчүүдийн 5-10%-д халдвар архагшиж, хавдрын урьдал эмгэг рүү шилжиж, эрт үед нь илрүүлж эмчлээгүй тохиолдолд ихэнхдээ 15-20 жилийн дараа умайн хүзүүний хорт хавдарт шилждэг.

БАГА ЭРСДЭЛТЭЙ ХПВ-ИЙН ХАЛДВАР ӨВЧИН ҮҮСГЭДЭГ ҮҮ?

Тийм. Бага эрсдэлтэй ХПВ нь бэлгийн үү, ургацаг үүсгэдэг. Бэлгийн үү, ургацгийн 10 тохиолдлын 9 нь ХПВ-ийн 6 болон 11-р хэв шинжээр үүсгэгддэг.



II. ХПВ-ЭЭР ҮҮСГЭГДСЭН ХАВДРУУДАЙ ХОЛБООТОЙ АСУУЛТУУД



УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХОРТ ХАВДАР ГЭЖ ЮУ ВЭ?

Умайн хүзүүний хорт хавдрын (УХХХ) бүх тохиолдол ХПВ-ийн халдвартай холбоотой байдаг. Өндөр эрсдэлтэй ХПВ-ийн хэв шинжийн халдвар нь умайн хүзүүний эсүүдэд өөрчлөлт үүсгэж, умайн хүзүүний хавдрын урьдал эмгэгт, эмчилгээ хийгдээгүй тохиолдолд

хорт хавдарт шилждэг. УХХХ-ыг эрт илрүүлсэн тохиолдолд бүрэн эмчлэгдэх боломжтой.

Харин эрт илрүүлж, эмчилгээ хийгээгүй тохиолдолд үхэлд хүргэнэ. Жил бүр дэлхий даяар 266,000 эмэгтэй УХХХ-ын улмаас нас бардаг бөгөөд тэдний 85 гаруй хувь нь хөгжиж буй орнуудын эмэгтэйчүүд байна.



ХПВ-ИЙН ХАЛДВАР АВСНААС ХОЙШ ЯМАР ХУГАЦААНД ХОРТ ХАВДАР ҮҮСЭХ ВЭ?

Халдвар авсан ихэнх хүмүүст шинж тэмдэг илрэхгүй. ХПВ-ийн халдвар авснаас хойш УХХХ үүсэх хугацаа ойролцоогоор 15-20 жил байдаг. 45 нас хүрсэн нийт хүмүүсийн 80 гаруй хувь нь ХПВ-ийн халдварыг авсан байдаг. Харин 10 хувь орчим нь ХПВ-ийн шалтгаант умайн хүзүүний хорт хавдар, умайн хүзүүний хорт хавдрын урьдал, үтрээ, хошногны хорт хавдар, ам залгиурын хорт хавдар, шодойн хорт хавдар, бэлгийн үү ургацаг үүсэх шалтгаан болж байна.

ЭМЭГТЭЙ ХҮН УХХХ-ААР ӨВДСӨН ЭСЭХИЙГ ГАДНААС НЬ ХАРААД МЭДЭХ БОЛОМЖТОЙ ЮУ?

Үгүй. УХХХ-аар өвдсөн эмэгтэй ч өөрөө өвчин хүндэртэл мэддэггүй. Тиймээс УХХХ-ыг илрүүлэхийн тулд эрт илрүүлэг, эсийн шинжилгээ ПАП, өндөр эрсдэлтэй ХПВ-ийн хэв шинжийг илрүүлэх ПГУ шинжилгээ хийлгэх шаардлагатай.

УХХХ-ЫН ӨВЧЛӨЛ МАНАЙ УЛСАД ЯМАР БАЙДАГ ВЭ?

УХХХ нь эмэгтэйчүүдийн дундах хавдрын өвчлөлийн 2-р, нас баралтын 3-р байранд байна. 2024 онд УХХХ-ын 521 тохиолдол шинээр бүртгэгдэж, 167 эмэгтэй уг хавдрын улмаас нас барсан. УХХХ-ын 47 хувь хожуу үе шатанд оношлогдож байна.

УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХОРТ ХАВДРЫН ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛ ЮУ БАЙДАГ ВЭ?

УХХХ-ын үндсэн эрсдэлт хүчин зүйл нь өндөр эрсдэл бүхий ХПВ-ийн халдвар байдаг. Бусад эрсдэлт хүчин зүйлсэд:

- Бэлгийн харьцаанд эрт орох,
- Бэлгийн олон хавьтагчтай байх,

- 3 ба түүнээс дээш удаа жирэмслэх,
- Тамхи татах,
- Дархлаа сул байх, ХДХВ-ийн халдвартай байх,
- Бэлгийн замын бусад халдвартай байх зэрэг ордог.

ХПВ БОЛОН УХХХ-ЫГ ШИНЖИЛЖ БОЛОХ УУ?

Болно: Шинжилгээний дараах 2 аргаар эрт илрүүлэх боломжтой.

1. Умайн хүзүүний эсийн шинжилгээ (ПАП)
2. Өндөр эрсдэлтэй ХПВ-ийн хэв шинжийн халдварыг илрүүлэх ПГУ шинжилгээ

ХПВ-ИЙН ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ БОЛОМЖТОЙ ЮУ?

Тийм. ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтанд хамрагдах нь анхдагч урьдчилан сэргийлэлтийн гол арга юм. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь УХХХ-ын 10 тохиолдлын 9, бэлгийн үү, ургацгийн 10 тохиолдлын 9-ийг үүсгэдэг ХПВ-ийн хэв шинжүүдээс сэргийлнэ.

ВАКЦИНААР ХПВ-ИЙН ХАЛДВАР БОЛОН УХХХ-ЫГ ЭМЧИЛЖ БОЛОХ УУ?

Үгүй. Вакцин нь УХХХ-ыг эмчлэхгүй. Тийм учраас ХПВ-ийн халдвар авахаас өмнө буюу бэлгийн харьцаанд орохоос өмнө вакцин хийлгэж хамгаална. Вакцин хийлгэсэн ч УХХХ-ын урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдах нь чухал.



III. ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУЛТУУД



ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТАНД ХАМРАГДАХ ЁСТОЙ ЮУ?



Тийм. Бэлгийн харьцаанд орохоос өмнө дархлаажуулалтанд хамрагдах нь хавдар үүсгэдэг хамгийн өндөр эрсдэлтэй ХПВ-ийн хэв шинжүүдийн халдвараас хамгаална.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН ХЭРХЭН ҮЙЛЧИЛДЭГ ВЭ?

Вакцин нь тарьсаны дараа хүний биед ХПВ-ийн халдвартай тэмцэх эсрэг биеийг үүсгэх замаар дархлааны системд дэмжлэг үзүүлдэг. 4 цэнт ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь 6, 11, 16, 18-р хэв шинжүүдээс 100 хувь хамгаална.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫГ ЯАЖ ГАРГАЖ АВДАГ ВЭ?

ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь ДНХ-ийн рекомбинант аргаар ХПВ-ийн хэв шинж тус бүрээс бүрхүүл уургийг цэвэршүүлэн гаргаж авсан вирус төст хэсгүүдийг агуулдаг. Эдгээр вакцин нь вирусийн ДНХ-ийг агуулдаггүй, амьд вакцин биш тул эсийг халдварлуулж, үрждэггүй, ХПВ-ийн халдвар эсвэл хавдар үүсгэдэггүй.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ЯМАР ВАКЦИН БАЙДАГ ВЭ?

Өнөөдрийн байдлаар ХПВ-ийн халдварын эсрэг хэд хэдэн төрлийн вакцин ашиглагдаж байна. Үүнд:

- 2 цэнт вакцин: өндөр эрсдэлтэй ХПВ-ийн 16 болон 18-р хэв шинжүүдээс хамгаална.
- 4 цэнт вакцин: ХПВ-ийн 6, 11, 16 болон 18-р хэв шинжүүдээс хамгаална.
- 9 цэнт вакцин: ХПВ-ийн 6, 11, 16, 18, 31, 33, 45, 52 болон 58-р хэв шинжүүдээс хамгаална.

МАНАЙ УЛС ЯМАР ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭЖ БАЙГАА ВЭ?

Манай улс 2006 онд ДЭМБ-аас зөвшөөрөл авсан, АНУ-ын Мерк Шарп үйлдвэрийн ХПВ-ийн халдварын эсрэг 4 цэнт вакциныг ашиглаж байна. Энэхүү вакцин нь ХПВ-ийн 6, 11, 16 болон 18-р хэв шинжүүдээс хамгаалахаас гадна 31, 33 болон 45-р хэв шинжээс давхар хамгаалдаг.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН ДАХЬ БОДИСУУД АЮУЛГҮЙ ЮУ?

Тийм. ХПВ-ийн халдварын эсрэг вакцины найрлага дахь бодисууд хүний биед аюулгүй. Вирус төст хэсгүүд нь вирусийн өөрийн генетикийн материал агуулаагүй, зөвхөн ХПВ-ийн уургийн бүрхүүлийг агуулдаг. Вирус төст хэсгүүдтэй тул вакциныг тарихад дархлааны систем ХПВ-ийн халдварын эсрэг хамгаалалтын эсрэг бие үүсгэж эхэлдэг.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫ НАЙРЛАГА ДАХЬ БОДИСУУД ЯМАР ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ ВЭ?

Вакцины найрлага дахь бодисууд хүний биед аюулгүй. Вакцин нь бусад эмийн адил нэмэлт бодисыг маш бага хэмжээгээр агуулсан байдаг.



Нэмэлт бодисууд нь ХПВ-ийн халдварын эсрэг вакцины үйлчилгээг үр дүнтэй болгох зориулалттай бөгөөд бусад вакцин, эмийн найрлагад адилхан бага тунгаар агуулагдаж байдаг. Тухайлбал:

- Хөнгөн цагааны давсыг 80 гаруй жил вакцины үйлдвэрлэлд ашиглаж ирсэн. Вакцин дахь хөнгөн цагааны давсны агууламж маш бага хэмжээтэй байдаг.
- Л-гистидин нь хоол хүнсэн дэх чухал амин хүчлийн нэг бөгөөд элэгний хавдрын эсрэг зарим вакцины найрлагад ордог.
- Полисорбат-80 нь мөхөөлдөс зэрэг зарим хүнсний найрлагад ордог. Зарим төрлийн хүүхдийн вакцин болон эмийн найрлагад агуулагддаг.
- Борын натрийн давс нь зарим төрлийн вакцин болон нүдний дусаалга зэрэг эмийн найрлагад ордог.
- Натрийн хлоридын давс нь хүний биеийн хэвийн үйл ажиллагаанд хэрэгцээтэй давс.
- Натрийн фосфатын давснууд нь түгээмэл хэрэглэгддэг, аюулгүй юм. Эдгээр нь хүчил шүлтийн тэнцвэртэй байдлыг хангах, вакцины идэвхтэй нэгдлүүдийг тунахаас сэргийлдэг.

ХӨНГӨН ЦАГААН НЬ ХҮНИЙ БИЕД АЮУЛГҮЙ ЮУ?

Тийм. Вакцины аюулгүй байдлын дэлхийн зөвлөлдөх хороо бүх нотолгоо, судалгааг тогтмол хянасны үндсэн дээр хөнгөн цагаан агуулсан вакцин эрүүл мэндэд үзүүлэх эрсдэл байхгүй байна гэж дүгнэсэн. Вакцин дахь хөнгөн цагааны агууламж маш өчүүхэн байдаг. Хүн өдөр тутмын хоол хүнсээр дамжуулан вакцинтай харьцуулахад 35 дахин их хэмжээний хөнгөн цагааныг авдаг. Хөнгөн цагаан нь жимс, хүнсний ногоо, шар айраг, дарс, амтлагч, гурил, үр тариа, самар, сүүн бүтээгдэхүүн, хүүхдийн сүүн тэжээл, зөгийн бал зэрэг олон төрлийн хоол хүнс, ундаанд агуулагддаг бөгөөд насанд хүрэгчид өдөрт 7-9 миллиграмм хөнгөн цагаан хэрэглэдэг. Харин ХПВ-ийн халдварын эсрэг вакцинд 0,225 микрограмм агуулагддаг.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫ НАЙРЛАГАД МӨНГӨН УС ОРДОГ УУ?

Үгүй. ХПВ-ийн халдварын эсрэг вакцины найрлагад тиомеросал буюу мөнгөн ус агуулагддаггүй.



ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН ХЭЗЭЭНЭЭС ХЭРЭГЛЭЭНД НЭВТЭРСЭН БЭ?

ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг 2006 оноос хойш хийж байна. Хамгийн анхны 4 цэнт ХПВ-ийн халдварын эсрэг вакцин 2006 онд, 2 цэнт вакцин 2007 онд, 9 цэнт вакцин 2014 онд ДЭМБ-аас лиценз зөвшөөрөл авсан.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНД ХЭР ОЛОН ХҮН ХАМРАГДСАН БЭ?

Тийм. 2006 оноос хойш дэлхий дахинд 500 сая тун ХПВ-ийн халдварын эсрэг вакцинд 270 гаруй сая хүн хамрагдаад байна.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫГ ОЛОН УЛС ОРНУУД ХЭРЭГЛЭЖ БАЙГАА ЮУ?

Тийм. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин дэлхийн 149 улсад дархлаажуулалтын товлолд орсон бөгөөд 76 оронд охид, хөвгүүдийн аль алинд нь хийж байна.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНД ХЭН ХАМРАГДАХ ВЭ?

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 472 дугаар тогтоолоор батлагдсан "Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлол"-ын дагуу 11 настай бүх хүүхдийг (охид, хөвгүүд) нэг тунгаар дархлаажуулна.

ЯАГААД ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫГ 11 НАСАНД ХИЙХ ВЭ?

11 настай хүүхдийг дархлаажуулахад үүсэх эсрэг биеийн түвшин түүнээс дээш насныхантай харьцуулахад өндөр бөгөөд дархлаа сайн тогтдог. Өсвөр насны хүүхдийг бэлгийн харьцаанд орохоос нь өмнө вакцинд хамруулах нь хамгийн үр дүнтэй нь нотлогдсон.

САЯХАН БУСАД ӨВЧНИЙ ЭСРЭГ ВАКЦИН ХИЙЛГЭСЭН БОЛ ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН ХИЙЛГЭЖ БОЛОХ УУ?

Үгүй. Бусад вакцинаас хойш 1 сарын дараа хийлгэж болно.

ЯАГААД ОХИДУУДАД ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫГ ХИЙЖ БАЙГАА ВЭ?

- ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтын хөтөлбөрийн гол зорилго нь ХПВ-ийн халдвараар үүсгэгддэг умайн хүзүүний хавдраас эмэгтэйчүүдийг сэргийлэх юм.
- Охидыг вакцинжуулснаар ирээдүйд вирусийн халдвар авах, улмаар умайн хүзүүний хорт хавдраар өвчлөх эрсдэлээс хамгаална.
- Хүүхдүүдийг эрт хамруулсанаар сүргийн дархлаа үүсгэж, вирусийн тархалтыг бууруулна.
- 9-14 насны охидыг ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтанд хамруулах ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу манай улс 11 настай охидыг дархлаажуулж байна.

ХӨВГҮҮДЭД ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫГ ХИЙХ ЁСТОЙ ЮУ?

Тийм.

- ХПВ-ийн халдвар нь шодой, хошног, хүзүү толгойны хавдар, бэлгийн үү, ургацаг үүсгэдэг тул энэхүү вакцин хөвгүүдийг эдгээр өвчнөөс хамгаалдаг.
- Түүнээс гадна эрэгтэй бэлгийн хамтрагчийг хамгаалснаар, умайн хүзүүний хавдраас шууд бусаар сэргийлэхэд нөлөө үзүүлнэ.



ЯАГААД ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫГ 2 ТУНГААР БИШ, НЭГ ТУНГААР ХИЙДЭГ БОЛГОСОН БЭ?

ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу анх ихэнх орнууд ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг 2 тунгаар дархлаажуултад нэвтрүүлсэн. 2023 онд ДЭМБ уг вакциныг 1 тунгаар хэрэглэх нь эрүүл мэндийн болон эдийн засгийн үр дүнтэй гэдгийг зөвлөмж болгосон. Ингэхдээ ХПВ-ийн эсрэг вакцины талаарх эрдэмтдийн судалгаа, дэлхийн дархлаажуулалтын шинжээчдийн стратегийн зөвлөх хорооны шийдвэрийг үндэслэсэн юм. Хөгжиж буй орнууд 1 тунгаар 2 хүйсээ хамгаалах нь эдийн засгийн хувьд илүү үр дүнтэй гэж үзэж байна.

ТУСГАЙ ХЭРЭГ ЦЭЭТ ХҮҮХДЭД ВАКЦИН ХИЙЛГЭЖ БОЛОХ УУ?

Болио. ХПВ-ийн халдварын эсрэг вакцины эсрэг заалт болохгүй.

ЯМАР ХҮҮХДЭД ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫГ ХИЙЖ БОЛОХГҮЙ ВЭ?

Уг вакцины найрлаганд орсон бодист харшилтай, өмнө нь вакцин хийлгэхэд харшлын урвал өгсөн болон ямар нэг цочмог өвчнөөр өвдсөн, хорт хавдрын эсрэг хими болон туяа эмчилгээ, дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэж байгаа хүүхдэд уг вакциныг хийж болохгүй. Цочмог халдварт өвчнөөр өвдсөн бол 1 сарын дараа, цочмог гепатитаар өвдсөн бол 6 сарын дараа вакцин хийнэ.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫГ ТОВЛОЛЫН БУС НАСНЫ ХҮҮХЭД ХИЙЛГЭЖ БОЛОХ УУ?

Болио. ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг үйлдвэрлэгчийн зааврын дагуу 9-26 насныханд хийхийг зөвлөсөн байдаг. Хэрэв 12-14 насны хүүхэд бол 1 тунгаар дархлаажуулна. Харин 15 буюу түүнээс дээш насныхан 3 тунгаар дархлаажуулна. Гурван тунгийн товллоор дархлаажуулах бол эхний тунгаас 2 сарын дараа хоёрдугаар тун, эхний тунгаас 6 сарын дараа гуравдугаар тунгаар дархлаажуулна. Иргэн сайн дурын үндсэн дээр өөрийн хүсэлтээр вакцины төлбөрийг төлж харьяа аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төв, ХӨСҮТ-ийн Сайн дурын дархлаажуулалтын кабинетад хандаж вакцинд хамрагдаж болно.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫГ БЭЛГИЙН ХАРЬЦААНД ОРСОН ХҮН ХИЙЛГЭЖ БОЛОХ УУ?

Тийм. Бэлгийн харьцаанд орсон хүмүүс ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийлгэж болно. Хэрэв ХПВ-ийн 6,11,16 эсвэл 18-р хэв шинжийн халдвар авсан бол тэр хэв шинжээс хамгаалагдах боломжгүй. Иймд вакцинаар бүрэн сэргийлэхийн тулд бэлгийн харьцаанд орохоос өмнө 9-14 насанд дархлаажуулах нь үр дүнтэй.

ХДХВ-ИЙН ХАЛДВАРТАЙ ХҮҮХЭД ВАКЦИН ХИЙЛГЭЖ БОЛОХ УУ?

Тийм. ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг ХДХВ-ийн халдвартай хүнд хийж болно. Вакцин үйлдвэрлэгчийн зааврын дагуу ХДХВ-ийн халдвартай хүнд хийх нь эсрэг заалт болохгүй. ХДХВ-ийн халдвартай хүнд гурван удаагийн тунгаар дархлаажуулна.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫГ ХЭРХЭН ХИЙХ ВЭ?

ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтыг бусад вакцины адилаар бугалганы булчинд тарина.

САЯХАН ӨӨР ӨВЧНИЙ ЭСРЭГ ВАКЦИН ХИЙЛГЭСЭН ХҮҮХДЭД ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН ХИЙЛГЭЖ БОЛОХ УУ ?

Өөр вакцин хийлгэснээс хойш 1 сарын дараа хийлгэж болно.

ХПВ-ИЙН ЭСРЭГ ВАКЦИН ХИЙЛГЭСНИЙ ДАРАА АНХААРАХ ЗҮЙЛС ЮУ ВЭ?

ХПВ-ийн эсрэг вакцин хийлгэсний дараа ажиглалтын өрөөнд 15-30 минут өөрийн биеийг ажиглана. Тарилга хийсэн хэсэгт вакцин тариулсан өдөртөө ус хүргэхгүй, цохиж, маажиж, нухахгүй, эм, тос, ариутгалын бодис зэргийг түрхэхгүй, хүйтэн зүйл уухгүй, дулаан хувцаслах хэрэгтэй. Өөр бусад ямар нэгэн шинж тэмдэг илэрвэл яаралтай эмчид хандана.

ХПВ-ИЙН ЭСРЭГ ВАКЦИН ХИЙЛГЭСНИЙ ДАРАА УХААН АЛДАЖ УНАДАГ УУ ?

Өсвөр насны зарим хүүхэд тариа хийлгэх айдсаас улбаалан муужрах, ухаан алдах тохиолдлууд бүртгэгдсэн байдаг. Иймд вакцин хийлгэсний дараа 15-30 минут суулгаж ажиглах нь чухал.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН ХЭР ҮР ДҮНТЭЙ БАЙГАА ВЭ?

ХПВ-ийн халдварын эсрэг вакцинжуулалтыг эрт эхлүүлсэн орнуудын дунд хийсэн судалгааны дүнгээр ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь:

- Вакцин хийлгэсэн бүлэгт ХПВ-ийн халдварын өндөр эрсдэлтэй хэв шинжүүдээр (ХПВ-ийн 16 болон 18-р хэв шинж) үүсгэгддэг халдварыг 90% бууруулсан
- Бэлгийн үүгийн тархалтыг 88% бууруулсан
- Залуу эмэгтэйчүүдийн дунд умайн хүзүүний хавдрын урьдал эмгэг үүсэх эрсдэлийг (CIN2 болон 3) 70% бууруулсан.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫ ДАРААХ ХАМГААЛАЛТ ХЭР УДААН ҮРГЭЛЖЛЭХ ВЭ?



12 жилийн турш 2 болон 4 цэнт вакцин хийлгэсэн хүмүүсийг дагаж судалсан судалгаагаар энэ хугацаанд дархлаа буурсан шинж тэмдэг илрээгүй байна. Нэг тун 4 цэнт ХПВ-ийн халдварын эсрэг вакцины дараах дархлаа удаан хугацаанд хадгалагдах бөгөөд дархлаажуулснаас хойш 10-аас дээш жил эсрэг биеийн титрийн хэмжээ тогтвортой өндөр, 15 жил ХПВ-ийн 16,18-р хэв шинжийн халдвар, хавдраас хамгаалсан байна.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН ХИЙЛГЭСЭН ЭМЭГТЭЙЧҮҮД УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГТ ХАМРАГДАХ ХЭРЭГТЭЙ ЮУ?

Тийм. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь умайн хүзүүний хорт хавдрын 10 тохиолдлын 9-ийг үүсгэдэг ХПВ-ийн хэв шинжээс хамгаалдаг боловч бусад төрлийн ХПВ-ээс хамгаалдаггүй. Иймд ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтанд хамрагдсан ч эрт илрүүлэг, ПАП шинжилгээ болон ХПВ илрүүлэх шинжилгээнд тогтмол хамрагдах нь зүйтэй.



ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫ ДАРАА ХАРИУ УРВАЛ ИЛЭРДЭГ ҮҮ?

Тийм. Бусад вакцин, эмийн адил ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийлгэсний дараа вакцин тарьсан газар өвдөх (10 хүний 8 хүнд илэрдэг), улайх, хавдах, толгой өвдөх (10 хүний 3 хүнд), бага зэрэг халуурах (10 хүний 1 хүнд илэрдэг) зэрэг хөнгөн шинж тэмдэг илэрч болно. Эдгээр шинж тэмдгүүд хэдэн цагаас 1-2 өдөр үргэлжилж ихэвчлэн аяндаа арилдаг.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН ХАРШЛЫН УРВАЛ ҮҮСГЭХ БОЛОМЖТОЙ ЮУ?

Тийм. Бүх төрлийн эм, вакцин, зарим хүнс, шавьжны хазалт харшлын урвал үүсгэж болдгийн адил ХПВ-ийн халдварын эсрэг вакцины найрлага дахь тодорхой бодист харшилтай хүмүүст урвал илэрч болно. Маш цөөн тохиолдолд (нэг сая хүний 1 хүнд илэрдэг) вакцины дараа хийснээс хойш хэдэн минутын дараа амьсгалахад хэцүү болох буюу анафилаксийн шок гэгдэх харшлын урвал бүртгэгдсэн байдаг. Иймд вакцин хийлгэсний дараагаар 15-30 минутын турш ажиглах шаардлагатай. Хэрэв толгой эргэх, амьсгал давчдах шинж тэмдэг илэрвэл эмчид яаралтай хандах хэрэгтэй.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫ ДАРААХ ХАРИУ УРВАЛ ҮҮСЭХ ЭРСДЭЛИЙГ БАГАСГАХ БОЛОМЖТОЙ ЮУ?

Тийм. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийлгэсний дараа урвал хүндрэл гарах магадлал маш бага юм. Гэвч дараах зүйлийг анхаарахад илүүдэхгүй. Үүнд:

- Хүүхэд өмнө нь вакцин хийлгэсний дараа харшил илэрч байсан бол эмчдээ мэдэгдэх.
- Вакцин хийлгэсний дараагаар 15 минутын турш анзаарч, ямар нэгэн харшлын шинж тэмдэг илрэхийг ажиглаж, эрт илрүүлж, хариу арга хэмжээ түргэн шуурхай авах.
- Вакцин тарьсан газарт улайх, хавдах, халуурах, бие загатнах зэрэг шинж тэмдэг илрэхийг ажиглах. Эдгээр шинж тэмдэг түгээмэл тохиолддог бөгөөд 1-2 хоног үргэлжилнэ гэдгийг хүүхдүүдэд ойлгуулах.

- Хэвийн бус шинж тэмдгийг эмчид мэдэгдэх. Ийм тохиолдлыг вакцинтай холбоотой эсэхийг нарийвчлан судалдаг.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫ ДАРАА УРТ ХУГАЦААНЫ УРВАЛ ХҮНДРЭЛ БАЙДАГ УУ?

Үгүй. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь хамгийн их судлагдсан вакцин юм. Урт хугацааны туршид үзүүлсэн урвал хүндрэл бүртгэгдээгүй.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН АЮУЛГҮЙ ЮУ?



Тийм. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь хамгийн аюулгүй вакцин юм. Энэхүү вакциныг зах зээлд гаргах зөвшөөрөл лиценз өгч, хүмүүст хийхээс өмнө эмнэл зүйн туршилт судалгаагаар аюулгүй байдал, үр нөлөөг маш нарийн судалсан. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Вакцины аюулгүй байдлын дэлхийн зөвлөлдөх хороо маш аюулгүй гэж үзсэн байна. Хүчтэй харшлын урвал буюу анафилаксийн шок (нэг сая тунд 1,7 тохиолдол) болон ухаан алдаж унах тохиолдол бусад вакцины адилаар маш ховор байна.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЫГ ТОГТМОЛ СУДАЛДАГ УУ?

Тийм. ДЭМБ-ын Вакцины аюулгүй байдлын дэлхийн зөвлөлдөх хороо дэлхийн хэмжээнд ХПВ-ийн халдварын эсрэг вакцины аюулгүй байдлын талаар хийгдсэн бүх шинжлэх ухааны нотолгоо судалгаанууд, вакцинтай холбоотой байх магадлалтай вакцины дараах урвал хүндрэлийн тохиолдол бүрийг хянаж, тогтмол үнэлгээ хийдэг. Энэхүү хороо ХПВ-ийн халдварын эсрэг вакцины аюулгүй байдлыг анх удаа 2007 онд, түүнээс хойш 2008, 2009, 2013, 2014, 2015, 2017 онуудад, хамгийн сүүлд 2019 онд хянаж үзэн, вакцинтай холбоотой ноцтой урвал хүндрэл бүртгэгдээгүй тул өсвөр насны хүүхдүүдэд хийхэд аюулгүйг баталсан.

ЯПОН УЛС ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН ХИЙЖ БАЙГАА ЮУ?

Тийм. Япон улс 2010 онд охидод ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг зарим мужуудад хийж эхлэн, 2013 оны 4-р сард дархлаажуулалтын үндэсний төвлөлд оруулж, вакцины хамрагдалд 70 хувьтай байсан. 2013 оны зун хэвлэл мэдээллээр гарсан вакцины дараах урвал хүндрэлийн талаарх (архаг хэсэгчилсэн өвдөлтийн хам шинж) мэдээлэлтэй холбоотой Японы засгийн газар ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтын хөтөлбөрийг түр зогсоосон. Нарийн үнэлгээ хийсний дараагаар 2021 оны 11-р сард Японы Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас уг вакциныг аюулгүй гэж үзэн, 12-16 насны охидод ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг хэрэглэхийг албан ёсоор зөвлөсөн.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН ЧАНАРТАЙ ЮУ?

Тийм. ДЭМБ, Европын Эмийн Агентлаг, улс орнуудын үндэсний зохицуулалтын байгууллагууд болон бусад олон байгууллагууд вакцины шинжилгээ, үйлдвэрлэл, тээвэрлэлт, хэрэглээ зэрэг бүх үе шатанд вакцины аюулгүй байдал, чанарыг маш нарийн хянадаг.

ВАКЦИНЫ ЧАНАРЫГ ХЭРХЭН ХЯНАДАГ ВЭ?

Ямар нэгэн вакцины лиценз авахаас өмнө эмнэл зүйн туршилт судалгаагаар вакциныг мянга мянган сайн дурынханд хийж, үр дүнг вакцин хийлгээгүй хүмүүстэй харьцуулан гаж нөлөөг нарийн судалдаг.

Вакцин аюулгүй, үр дүнтэйг баталсаны дараагаар улс орнуудын үндэсний зохицуулалтын байгууллагууд тухайн улсдаа бүртгэж лиценз олгох эсэх талаар боломжит нотолгоонуудыг судалсны үндсэн дээр шийдвэрээ гаргадаг. Вакцин лицензээ авч, товллын дарлаажуулалтанд орсны дараагаар дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг үргэлжлүүлэн хянаж, үнэлдэг.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН НӨХӨН ҮРЖИХҮЙД НӨЛӨӨЛДӨГ ҮҮ?

Үгүй. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нөхөн үржихүйд нөлөө үзүүлдэггүй. 2006 онд анх лиценз авахаас өмнө хийгдсэн вакцины эмнэл зүйн туршилтууд, вакцин нэвтрүүлснээс хойших аюулгүй байдлын хяналт, судалгаанууд энэхүү вакцин эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйд ямар нэгэн асуудал үүсгэдэггүйг баталгаажуулсан байна. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь умайн хүзүүнд хавдрын урьдал эмгэг (шарх) болон умайн хүзүүний хавдар үүсэхээс хамгаалах замаар нөхөн үржихүйг хамгаалдаг.



Харин умайн хүзүүний хавдрын урьдал эмгэгийг эмчлэх мэс заслын эмчилгээ нь эмэгтэйчүүдийг жирэмслэхэд хэцүү болгодог, түүнчлэн жирэмсэн үед умайн хүзүүний хавдрын урьдал эмгэгийн мэс заслын бус, мэс заслын эмчилгээ аль аль нь дутуу төрөх, ураг эндэхэд хүргэдэг. ХПВ-ийн вакцин биш, харин умайн хүзүүний хавдрын эмчилгээ болох умайн хүзүү, умайг авах мэс засал, химийн эмчилгээ, туяа эмчилгээ нь эмэгтэйчүүдийг хүүхэд тээх боломжгүй болгодог байна.

ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН АУТИЗМ ҮҮСГЭДЭГ ҮҮ?

Үгүй. Олон улс (АНУ, Дани, Швед, Япон, Австрали гэх мэт)-ын эрдэмтдийн олон сая хүнийг хамруулан хийсэн судалгаагаар ХПВ-ийн эсрэг вакцин хийлгэсэн болон хийлгээгүй хүүхдүүдийн дунд аутизмын тохиолдлын ялгаа байхгүй байсан. Мөн ДЭМБ, АНУ-ын Өвчний хяналтын төв, Европын Эмийн Агентлаг, Австралийн Эрүүл мэндийн байгууллага бүгд ХПВ-ийн эсрэг вакцин аутизм үүсгэдэггүй гэдгийг албан ёсоор мэдэгдсэн байна.

Судалгааны үр дүнгээр вакцины найрлага дахь тогтворжуулагч бодис болох хөнгөн цагаан нь аутизм үүсгэх эрсдлийг нэмэгдүүлдэггүйг тогтоосон.

ХПВ-ИЙН ВАКЦИНЫГ ӨМНӨ НЬ МАНАЙ УЛСАД ХЭРЭГЛЭЖ БАЙСАН УУ?

Тийм. Манай улсад 2012 онд Улаанбаатар хотын Баянгол, Багануур дүүрэг, Өмнөговь, Сэлэнгэ аймгийн 10 мянга гаруй охидыг 3 тун ХПВ-ийн халдварын эсрэг вакцинаар 3 тунгаар дархлаажуулсан. 2022 оноос сайн дурын дархлаажуулалтаар хийсэн.

2012 ОНД МАНАЙ УЛСАД ХИЙСЭН ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН ҮР ДҮНТЭЙ БАЙСАН УУ?

Тийм. Нийслэлийн Баянгол, Багануур дүүрэг, Өмнөговь, Сэлэнгэ аймгийн ХПВ-ийн халдварын эсрэг 3 тун вакцинд хамрагдсан 925, ижил насны вакцинд хамрагдаагүй 978 эмэгтэйчүүдийг вакцин хийснээс хойш 5 жилийн дараа дагаж судалсан Хавдрын Үндэсний Зөвлөл НҮТББ-ын судалгаагаар вакцинд хамрагдсан бүлэгт ХПВ-ийн 16 болон 18-р хэв шинжийн тархалт вакцинд хамрагдаагүй бүлэгтэй харьцуулахад 4 дахин буурч, түүн дотроо ХПВ 16-р хэв шинжийн тархалт 10 дахин буурсан байна.

Эдгээр эмэгтэйчүүдийг вакцин хийснээс хойш 11 жилийн дараа дагаж судалсан судалгаагаар вакцинд хамрагдсан бүлэгт ХПВ-ийн 16 болон 18-р хэв шинжийн тархалт вакцинд хамрагдаагүй бүлэгтэй харьцуулахад 9 дахин буурч, түүн дотроо ХПВ 16-р хэв шинжийн тархалт 8 дахин буурсан байна. 3 тун ХПВ-ийн вакцин ХПВ-ийн өндөр эрсдэлтэй 16-р хэв шинжээс 5 жилийн дараа 90 хувь, 11 жилийн дараа 100 хувь хамгаалсан үр дүн гарсан байна.

2012 ОНД МАНАЙ УЛСАД ХИЙСЭН ХПВ-ИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИН ОХИДЫГ ҮРГҮЙДЭЛД ХҮРГЭСЭН ҮҮ?



Үгүй. Нийслэлийн Баянгол, Багануур дүүрэг, Өмнөговь, Сэлэнгэ аймгийн ХПВ-ийн халдварын эсрэг 3 тун вакцинд хамрагдсан 925, ижил насны вакцинд хамрагдаагүй 978 эмэгтэйчүүдийг вакцин хийснээс хойш судалсан Хавдрын Үндэсний Зөвлөл НҮТББ-ын судалгаагаар жирэмслэлт болон төрөлт 5 болон 11 жилийн дараа ХПВ-ийн вакцинд хамрагдсан бүлэг болон вакцингүй тухайн насны хяналтын бүлэгт ижил байсан бөгөөд жирэмслэлт, төрөлтөд ямар нэгэн нөлөө үзүүлээгүй байна.



IV. ХПВ, ХПВ-ИЙН ДАРХЛААЖУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ БУРУУ, ТАШАА ОЙЛГОЛТЫГ ЗАЛРУУЛАХУЙ



Аливаа асуудлын талаарх ташаа ойлголт, буруу мэдээллийг залруулах үйл явц нь тодорхой үе шатаар, нарийн зохион байгуулалттайгаар явагдах хэрэгцээтэй байдаг. Ташаа ойлголтыг залруулах үе шатууд:

Бэлтгэл үе. Хамгийн үр дүнтэй. Тухайн асуудлын талаар ташаа ойлголт, буруу мэдээлэл өргөн тархахаас өмнө найдвартай, бодит тоо баримт, мэдээллийг хүн амын дунд түгээнэ.

Хяналтын үе: Тухайн асуудлын талаар ташаа ойлголт, буруу мэдээлэл тарж эхэлсэн ч нийт хүн амын дунд тархаагүй үед авах арга хэмжээ юм. Энэ нь бодит, үнэн зөв мэдээллийг тодруулж, залруулах мэдээллийг бэлтгэх үе шат юм.

Сэдвийн өөрчлөлт: Ташаа ойлголт, буруу мэдээлэл тархсан хэдий ч, газар аваагүй үед зөв мэдээллийг түгээж, тарж буй буруу мэдээллийг өөрчлөх үе юм. Энэ үед зөв мэдээллийг өргөн хүрээтэй тараахад анхаарч ажиллах хэрэгцээтэй. Тухайлбал, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн үр дүн, вакцины аюулгүй байдлын талаар гэх мэт.

Залруулах үе: Энэ үе шатанд нэгэнт тархсан ташаа ойлголт, буруу мэдээллийг залруулах зорилготой идэвхтэй хэлэлцүүлэг өрнүүлж, баримт, нотолгоог гаргадаг. Ташаа ойлголт, буруу мэдээллийг залруулах үйл явц маш түвэгтэй. "Хуурмаг үнэн эффект" гэдэг нь буруу ташаа мэдээлэл байсан ч хүмүүс тухайн мэдээллийг хэдий чинээ олон удаа сонсоно, төдий чинээ итгэдгийг хэлдэг. Хэдий тухайн мэдээлэл буруу, ташаа ч тэр мэдээлэл хүмүүсийн шийдвэр гаргалтанд нөлөөлсөөр байдаг (өөрөөр хэлбэл ташаа мэдээлэл "цавуу шиг наалдамхай"). Иймд залруулга хийх тогтмол, цогц арга хэмжээ хэрэгцээтэй бөгөөд нотолгоонд суурилсан, бодит, итгэл төрүүлэхүйц мэдээлэл түгээх шаардлагатай байдаг.

Баримт	Анхааруулга	Төөрөгдөл	Баримт
Тодорхой, нотолгоотой, хүний ой тоонд хоногшихуйц баримтаар эхэлнэ.	Ташаа мэдээлэл буруу гэдгийг танилцуулна. Гэхдээ ташаа мэдээллийг олон удаа давтаж анхааралд оруулалгүй, нэг л удаа дурьдана.	Ташаа мэдээлэл яагаад буруу талаар тайлбарлана. Бодит нотолгоог ойлгоход хялбар аргаар өгнө.	Дүгнэлт болгож, гол үндсэн баримтыг дурьдана (хүмүүсийн хамгийн сүүлд тогтоох зүйл энэ байдаг). Цаад шалтгааныг тайлбарлахад анхаарна.

Түлхүүр мэдээлэл: Хүний Папиллома Вирус хүн амын дунд өргөн тархсан вирус юм



Хүн амын дундах ташаа мэдээлэл	Залруулга мэдээлэл	Эх сурвалж
ХПВ-ийн халдвар маш ховор тохиолддог тул охид, эмэгтэйчүүдийн хувьд санаа зовох асуудал биш	ХПВ-ээр үүсгэгдсэн халдвар нь маш өргөн тархсан байдаг. Хүн амын 80-90% амьдралынхаа туршид энэ вирусийн халдварыг авах магадлалтай ¹ . Эмэгтэйчүүдийн дундах ХПВ-ийн тархалт дунджаар 12%, улс орнууд дахь тархалт 2%-аас 42% хүртэл байдаг ² .	1 Human papillomavirus vaccines: WHO position paper (2022 update) 2 David Forman, Catherine de Martel, Charles J. Lacey, Isabelle Soerjomataram, Joannie Lortet-Tieulent, Laia Bruni, Jerome Vignat, Jacques Ferlay, Freddie Bray, Martin Plummer, Silvia Franceschi, Global Burden of Human Papillomavirus and Related Diseases, Vaccine, Volume 30, Supplement 5, 2012, Pages F12-F23,
Эрэгтэйчүүд ХПВ-ийн халдвар авдаггүй	ХПВ-ийн халдварын тархалт эрэгтэйчүүдийн дунд ч мөн адил өндөр байдаг. Эрэгтэйчүүдийн дундах өндөр эрсдэлтэй ХПВ-ийн тархалт 21% буюу таван эрэгтэй тутмын нэг нь уг вирусийн халдвартай байна ³ .	3 Bruni L, Albero G, Rowley J, Alemany L, Arbyn M, Giuliano AR, Markowitz LE, Broutet N, Taylor M. Global and regional estimates of genital human papillomavirus prevalence among men: a systematic review and meta-analysis. Lancet Glob Health. 2023 Sep;11(9):e1345-e1362
Хэрэв ХПВ-ийн халдвар авсан бол шинж тэмдэг илрэх тул халдвар авсанаа мэдэх боломжтой	ХПВ-ийн халдвар (70-90%) ихэнхдээ шинж тэмдэггүй байдаг тул халдварыг эмнэл зүйгээр илрүүлэх боломж хязгаарлагдмал ^{1,4} . Халдвар авсан хүн амын 90%-ээс дээш хувьд энэ вирус 1-2 жилийн дотор өөрөө арилдаг ^{1,6} .	

Бэлгийн олон хавьтагчтай л бол ХПВ-ийн халдвар авдаг	Олон бэлгийн хамтрагчтай байх нь халдвар авах эрсдэлийг нэмэгдүүлдэг. Гэвч ХПВ нь тархалт ихтэй вирус тул ХПВ-ийн халдварыг анхны бэлгийн хавьтлын үед ч авах эрсдэл өндөр байдаг ⁴ .	4 WHO (2022) 'Cervical Cancer'. Fact Sheet, 22 February. https://www.who.int/news-room/fact-sheets/detail/cervical-cancer
Зөвхөн бэлгийн харьцаанд орсон хүмүүс л ХПВ-ийн халдвар авдаг	ХПВ-ийн халдвар ихэвчлэн бэлгийн замаар (бэлгийн, аман, анал бэлгийн хавьтлын үед) дамждаг ч бэлэг эрхтэн орчмын арьс шүргэлцэхэд дамжиж болно. Мөн эхээс урагт төрөх замаар дамжин халдварладаг ⁵ .	5 WHO (2024) Human papillomavirus and cancer, Fact sheet, 5 March https://www.who.int/news-room/fact-sheets/detail/human-papilloma-virus-and-cancer
Бэлгэвч хэрэглэсэн тохиолдолд ХПВ-ийн халдварыг авахгүй	Бэлгэвч нь бэлгийн замаар дамждаг халдваруудаас хамгаална. ХПВ-ийн хувьд бэлгэвч халдвар авах эрсдэлийг бууруулдаг хэдий ч бэлэг эрхтэн орчмын арьсыг бүрэн далдалдаггүй учраас төдийлөн сайн хамгаалж чаддаггүй ⁶ .	6 Winer RL, Feng Q, Hughes JP, et al. Risk of female human papillomavirus acquisition associated with first male sex partner. Journal of Infectious Diseases 2008;197:279-82.
Зөвхөн бэлгийн замбараагүй явдалтай хүмүүс ХПВ-ийн халдвар авдаг тул энэ халдвар авах нь ичгүүртэй	ХПВ-ийн халдвар нь түгээмэл вирус бөгөөд энэ халдварыг анхны бэлгийн харьцааны үед авах боломжтой, зөвхөн бэлгийн замбараагүй явдалтай хүн л авдаг биш юм ^{7,8} . Эмэгтэйчүүдийн дундах судалгаагаар 5 эмэгтэй тутмын 2 нь ХПВ-ийн халдвар авсан тохиолдолд хүмүүс түүнийг юу гэх бол гэдгээс санаа зовдог гэж хариулсан байна. Иймд умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг хөтөлбөрийн хүрээнд ХПВ илрүүлэх шинжилгээ хийхдээ уг халдвар түгээмэл байдаг талаар ойлгуулахад анхаарах хэрэгтэй ⁹ .	7 WHO Questions and Answers about Human papilloma virus, 2024 8 Music, R. (2019) 'Raising Awareness of HPV – a View from Jo's Cervical Cancer Trust'. Public Health England blog, 30 May. https://phescreening.blog.gov.uk/2019/05/30/raising-awareness-of-hpv-a-view-from-joscervical-cancer-trust/?msclkid=bef20df-7b00411eca06af11702a85e5e (accessed 31 May 2022).
ХПВ-ийн халдвар хижээл насныханд илэрдэггүй	Халдварт өртөх 2 оргил үе байдаг ⁹ : • 25-аас доош насанд • 45-аас дээш насанд Зарим улс орнуудад ХПВ-ийн халдвар 45-аас дээш насанд бага зэрэг нэмэгддэг.	9 Bruni L., The frequency of HPV infection worldwide, HPV World, #35

Түлхүүр мэдээлэл: Умайн хүзүүний хорт хавдар 100% ХПВ-ийн халдвартай холбоотой

Хүн амын дундах ташаа мэдээлэл	Залруулга мэдээлэл	Эх сурвалж
ХПВ нь умайн хүзүүний хавдрын багахан хувийн шалтгаан болдог	Умайн хүзүүний хорт хавдрын бүх тохиолдол 100% ХПВ-ийн халдвартай холбоотой байдаг ^{1,2} .	1 WHO (2022) 'Cervical Cancer'. Fact Sheet, 22 February. https://www.who.int/news-room/fact-sheets/detail/cervical-cancer
Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх боломжгүй	ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь ХПВ-ийн хавдар үүсгэх өндөр эрсдэлтэй хэв шинжийн халдвар авах эрсдлийг бууруулах, хавдар үүсэхээс сэргийлэх үр дүнтэй аюулгүй арга юм ³ .	2 de Martel, C., Plummer, M., Vignat, J. & Franceschi, S. World-wide burden of cancer attributable to HPV by site, country and HPV type. Int. J. Cancer 141, 664–670 (2017)
ХПВ-ийн халдвар авсан бол хавдар тусдаг	ХПВ-ийн 200 гаруй хэв шинж байдаг. Үүнээс хавдар үүсгэх өндөр эрсдэлтэй ХПВ-ийн 12 хэв шинж байдаг ³ . ХПВ-ийн 16 болон 18-р хэв шинжүүд умайн хүзүүний хорт хавдрын 70%-ийг үүсгэдэг. Бусад 5 хэв шинж (ХПВ-ийн 45, 31, 33, 58, 52-р хэв шинжүүд) нь 20%-ийн шалтгаан болдог ⁴ .	3 Human papillomavirus vaccines: WHO position paper (2022 update)
Хэрэв ээж, эмээ нь умайн хүзүүний хавдраар өвдөж байсан бол удамшиж хавдар тусдаг	Умайн хүзүүний хорт хавдар нь удамшдаггүй ³ .	4 IARC Handbooks of cancer prevention, Cervical Cancer Screening, Volume 18, 2022
Урт хугацаанд бэлгийн идэвхгүй амьдралд байсан эмэгтэйчүүдийн хувьд умайн хүзүүний хорт хавдар тусах эрсдэл бага	ДЭМБ-ын судалгаагаар хэвийн дархлааны тогтолцоотой эмэгтэйчүүдийн хувьд өндөр эрсдэл бүхий вирусийн халдвар авсанаас хойш 15-20 жилийн дараа, дархлаа сул (ХДХВ-ийн халдвартай хүмүүс) эмэгтэйчүүдийн хувьд 5-10 жилийн дараа умайн хүзүүний хавдар үүсдэг байна ¹ . Энэ нь бэлгийн идэвхтэй, идэхгүйгээс хамаарахгүй байгаа тул ойрын хугацаанд бэлгийн харьцаанд ороогүй эмэгтэйчүүдэд ч умайн хүзүүний хорт хавдар оношлогдож болно.	

Түлхүүр мэдээлэл: ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь аюулгүй бөгөөд ХПВ-ийн шалтгаант халдвар, хавдрын урьдал эмгэг болон хорт хавдраас сэргийлэх үр дүнтэй анхдагч урьдчилан сэргийлэлт юм

Хүн амын дундах ташаа мэдээлэл	Залруулга мэдээлэл	Эх сурвалж
ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь ХПВ-ийн бүх төрлийн хэв шинжүүдээс хамгаалдаг	ХПВ-ийн халдварын эсрэг 4 цэнт Гардасил вакцин нь ХПВ-ийн хавдар үүсгэдэг хамгийн өндөр эрсдэлтэй ХПВ-ийн 6, 11, 16, 18-р хэв шинжүүдээс хамгаалдаг бөгөөд бусад хэв шинжээс хамгаалахгүй. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь умайн хүзүүний, хошного, ам залгиур, үтрээ, гадна бэлэг эрхтэн, шодойн хавдар зэрэг 6 төрлийн хавдраас хамгаална ¹ .	1 United States National Cancer Institute (2021) 'Human Papillomavirus Vaccines'. https://www.cancer.gov/about-cancer/causes-prevention/risk/infectious-agents/hpv-vaccine-fact-sheet#why-is-hpvpvaccination-important
ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь хаана ч хийгддэггүй шинэ вакцин.	ХПВ-ийн халдварын эсрэг вакцин 2006 оноос хэрэглэгдэж байгаа бөгөөд 2025 оны 2-р сарын байдлаар дэлхийн 146 улс оронд дархлаажуулалтын үндэсний төвлөлын дагуу хийгдэж байна ² . 15 жилийн турш вакцины аюулгүй байдлыг судалсан 160 гаруй судалгаагаар ХПВ-ийн халдварын эсрэг вакцины аюулгүй байдал нотлогдсон ³⁻⁵ .	2 ДЭМБ, https://www.who.int/teams/immunization-vaccines-and-biologicals/diseases/human-papillomavirus-vaccines-(HPV)/hpv-clearing-house/hpv-dashboard
ХПВ-ийн халдварын эсрэг вакцины зөвхөн хавдрын урьдал эмгэг дээр үзүүлэх үр нөлөөг судалсан бөгөөд умайн хүзүүний хорт хавдарт хэрхэн нөлөөлөх нь судлагдаагүй	ХПВ-ийн халдвар авсанаас хойш умайн хүзүүний хорт хавдар болох хүртэл урт хугацаа болох учраас вакцинжуулалтын эхний үеийн үр дүнг умайн хүзүүний хавдрын урьдал эмгэгийн жишээн дээр авч үзэж байна. Энэхүү вакцин умайн хүзүүний хорт хавдарт хэрхэн нөлөөлсөн талаар 10 жилийн дараа илүү тодорхой судалгааны үр дүнгүүд гарах болно. Хийгдсэн судалгаанаас харахад ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн дунд хамрагдаагүй эмэгтэйчүүдтэй харьцуулахад умайн хүзүүний хорт хавдрын тохиолдол 90 хувь буурсан байна ⁷ .	3 CDC (2020) 'Human Papillomavirus (HPV) Vaccine: Safety Information'. https://www.cdc.gov/vaccinesafety/vaccines/hpv-vaccine.html 4 WHO (2020) 'Human Papilloma Virus Vaccines and Infertility' ACVS meeting of 4–5 December 2019, in WHO Weekly Epidemiological Record of 24 January 2020, https://www.who.int/groups/global-advisorycommittee-on-vaccine-safety/topics/human-papilloma-virus-vaccines/infertility

Бэлгийн харьцаанд ороогүй хүүхдэд ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг бага насанд нь хийх нь үр дүнгүй	ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг тухайн вирус хүний биед орохоос өмнө эрт насанд хийх тусам илүү үр дүнтэй, дархлаа сайн тогтдог. ДЭМБ-аас хүүхдүүдийг бэлгийн харьцаанд орохоос нь өмнө 9-14 насанд дархлаажуулахыг зөвлөж байна ^{5,9} .	5 Observed rate of vaccine reactions: human papillo-ma virus vaccine. Geneva: World Health Organization; 2017 (https://cdn.who.int/media/docs/default-source/pvg/global-vaccine-safety/hpv-vaccine-rates-information-sheet-1217.pdf?sfvrsn=15d7ba4
ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг зөвхөн өсвөр насны хүүхдүүдэд хийдэг	ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг дархлаажуулалтын үндэсний товллын наснаас гадна 15-26 насны эмэгтэйчүүд сайн дурын дархлаажуулалтаар харъяа аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвд төлбөртэйгээр /23,000 төгрөг/ хийлгэнэ. 27-45 насны эмэгтэйчүүд, эрсдэлтэй бүлгийн хүмүүс (эрэгтэйчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрэгтэйчүүд, ХДХВ-ийн халдвартай, олон бэлгийн хамтрагчтай) эмчийн заалтаар хийлгэх боломжтой.	_4&download=true) 6 Global Advisory Committee on Vaccine Safety. Safety of HPV vaccines. Geneva: World Health Organization (https://www.who.int/groups/global-advisory-committee-on-vaccine-safety/topics/human-papillomavirus-vaccines/safety
ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг олон тун хийлгэх ёстой	2023 онд ДЭМБ-аас ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг 1 тунгаар хэрэглэх нь 2 тун хийлгэсэнтэй ижил үр дүнтэйгээс гадна эдийн засгийн хувьд үр ашигтайг нотолж, нэг тун хийхийг зөвлөмж болгосон ⁸ . Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 472 тоот тогтоолоор баталсан үндэсний товллын дагуу 11 насны бүх хүүхдийг ХПВ-ийн халдварын эсрэг вакцинаар нэг удаа дархлаажуулж байна.	7 Lei, J., Ploner, A., Elfström et al. (2020) 'HPV Vaccination and the Risk of Invasive Cervical Cancer'. The New England Journal of Medicine 383:1340-1348.
ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг эрт хийснээр бэлгийн замбараагүй амьдрал, эрсдэлтэй зан үйлийг нэмэгдүүлдэг.	ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтанд хамрагдах нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд аль алинд бэлгийн замбараагүй амьдралд хүргэдэггүй байна. Вакцин хийлгэсэн болон хийлгээгүй 521,879 оролцогчийг хамруулсан 20 гаруй судалгаагаар вакцин хийлгэсэн эмэгтэйчүүдийн дунд бэлгийн харьцаанд эрт орсон, бэлгийн олон хамтрагчтай болсон асуудал ажиглагдаагүй бөгөөд бэлгийн амьдрал, зан үйлийн хувьд бүлгүүдийн хувьд ялгаа байхгүй байсан байна ^{9,10} .	8 Human papillomavirus vaccines: WHO position paper (2022 update) 9 Brouwer, A., Delinger, R., Eisenbert, M. et al. (2019) 'HPV Vaccination Has Not Increased Sexual Activity or Accelerated Sexual Debut in a College-Aged Cohort of Men and Women'. BMC Public Health 19: 821

ХПВ-ийн халдварын эсрэг вакцин бусад төрлийн халдвараас сэргийлдэг.	ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь умайн хүзүү болон бусад ХПВ-ийн хамааралтай хавдраас сэргийлэх боловч бусад бэлгийн замаар дамжих халдваруудаас хамгаалахгүй ¹¹ .	10 Kasting ML, Shapiro GK, Rosberger Z, Kahn JA, Zimet GD. Tempest in a teapot: A systematic review of HPV vaccination and risk compensation research. Hum Vaccin Immunother. 2016;12(6):1435-50. doi:10.1080/21645515.2016.1141115
ХПВ-ийн халдвар авахад дархлаа тогтдог учраас вакцин хийх шаардлагагүй	ХПВ-ийн халдвар авсны дараа үүсэх эсрэг биеийн хэмжээ бага байх тул дархлаа тогтоц хангалтгүй байдаг. Харин ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийсэн тохиолдолд хангалттай дархлаа тогтдог ⁴ .	11 Radecki Breitkopf, C., Finney Rutton, L., Findley, V. et al. (2016) 'Awareness and Knowledge of Human Papillomavirus (HPV), HPV-Related Cancers, and HPV vaccines in an Uninsured Adult Clinic Population'. Cancer Medicine 5(11): 3346–3352.
9 цэнт ХПВ-ийн халдварын эсрэг вакцин л хамгийн сайн, олдоц ихтэй	ХПВ-ийн халдварын эсрэг 9 цэнт Гардасил вакцин нь АНУ-ын Мерк үйлдвэрт үйлдвэрлэгдсэн, ХПВ-ийн 9 хэв шинжээс хамгаалдаг. 2014 онд лиценз авч, 2016 оноос өндөр хөгжилтэй улс орнууд хийж эхэлсэн, ганц үйлдвэрлэгчтэй, олдоц бага, үнэ өндөр байна. Манай улсад хэрэглэгдэж буй 4 цэнт ХПВ-ийн халдварын эсрэг Гардасил вакцин нь АНУ-ын Мерк үйлдвэрт үйлдвэрлэгдсэн, ХПВ-ийн 4 хэв шинжээс (6,11,16,18) гадна гадна 31, 33 болон 45-р хэв шинжээс давхар хамгаалдаг. Монгол эмэгтэйчүүдийн дунд тохиолдож буй умайн хүзүүний хорт хавдрын 48,3%-д хавдар үүсгэх өндөр эрсдэлтэй ХПВ-ийн 16 болон 18-р хэв шинжүүд илэрсэн байна.	



Түлхүүр мэдээлэл: Хөвгүүдийг дархлаажуулснаар эрэгтэйчүүдийн дундах хорт хавдрыг бууруулах боломжтой

Хүн амын дундах ташаа мэдээлэл	Залруулга мэдээлэл	Эх сурвалж
ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг зөвхөн эмэгтэйчүүдэд л хийдэг	ХПВ-ийн халдварт эрэгтэй, эмэгтэй хүмүүс адилхан өртөх эрсдэлтэй учраас охид, хөвгүүдэд аль алинд нь ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг хийж ХПВ-ийн шалтгаант өвчлөл, хавдраас сэргийлдэг ¹ . Эрэгтэйчүүдийн дунд хошногони хавдрын 88%, шодойн хавдрын 50%, ам залгиурын хавдрын 30% ХПВ-ийн халдвартай холбоотой байдаг ² .	1Bruni L, Albero G, Rowley J, Alemany L, Arbyn M, Giuliano AR, Markowitz LE, Broutet N, Taylor M. Global and regional estimates of genital human papillomavirus prevalence among men: a systematic review and meta-analysis. Lancet Glob Health. 2023 Sep;11(9):e1345-e1362
ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь зөвхөн умайн хүзүүний хорт хавдраас сэргийлдэг тул хөвгүүдэд хийх шаардлагагүй	ХПВ нь эрэгтэйчүүдэд хошног, залгиур хоолой, шодойн хавдар үүсгэдэг. Мөн аль аль хүйсэд бэлгийн үү, ургацаг болон амьсгалын замын дахидаг папилломатозыг үүсгэдэг ³ . Иймд ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь эрэгтэйчүүдэд дээрх өвчлөл, хавдраас сэргийлдэг.	2 de Martel, C., Plummer, M., Vignat, J. & Franceschi, S. Worldwide burden of cancer attributable to HPV by site, country and HPV type. Int. J. Cancer 141, 664–670 (2017)
Улс орнууд хөвгүүддээ ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийдэггүй	2025 оны 2-р сарын байдлаар дэлхийн 76 улс охид, хөвгүүдэд аль алинд ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтыг хийж байна.	3WHO (2024) Human papillomavirus and cancer, Fact sheet, 5 March https://www.who.int/news-room/fact-sheets/detail/human-papilloma-virus-and-cancer
		4ДЭМБ, https://www.who.int/teams/immunization-vaccines-and-biologicals/diseases/human-papillomavirus-vaccines-(HPV)/hvp-clearing-house/hpv-dashboard



Түлхүүр мэдээлэл: ХПВ-ийн халдварын эсрэг вакцин болон түүний найрлага дах бодисууд эрүүл мэндэд аюулгүй, вакцин урт хугацаанд хамгаална

Хүн амын дундах ташаа мэдээлэл	Залруулга мэдээлэл	Эх сурвалж
ХПВ-ийн халдварын эсрэг вакцин огт судлагдаагүй, шинэ вакцин	ХПВ-ийн халдварын эсрэг вакцины анхны эмнэл зүйн туршилт судалгаа 1997 оноос эхэлж, эхний үр дүн 2002 онд хэвлэгдэж байсан. Анхны 4 цэнт вакцин 2006 онд, 2 цэнт вакцин 2007 онд ДЭМБ-аас лиценз авсан. 2007 оноос хойш дархлаажуулалтын товлонд орж хэрэглэгдэж байгаа бөгөөд аюулгүй байдал нь олон тооны судалгаагаар судлагдсан. ДЭМБ, АНУ-ын Хүнс эмийн агентлаг, Австралийн Эмчилгээний бүтээгдэхүүний байгууллага зэрэг олон байгууллагаар баталгаажсан. Өнөөдрийн байдлаар 500 сая тун вакцин 100 сая хүнд хийгдсэн байна ^{1,2} .	1 Global Advisory Committee on Vaccine Safety. Safety of HPV vaccines. Geneva: World Health Organization (https://www.who.int/groups/global-advisory-committee-on-vaccine-safety/topics/human-papillomavirus-vaccines/safety) 2 National centre for Immunization Research and Surveillance, Human papillomavirus (HPV) vaccines for Australians, Fact sheet, 2023 3 CDC (2020) 'Human Papilloma-virus (HPV) Vaccine: Safety Information'. https://www.cdc.gov/vaccinesafety/vaccines/hpv-vaccine.html
ХПВ-ийн халдварын эсрэг вакцин эрүүл мэндэд аюултай, гаж нөлөө ихтэй	Бусад вакцин, эмийн адил ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийлгэсний дараа вакцин тарьсан газар өвдөх (10 хүний 8 хүнд илэрдэг), улайх, хавдах, толгой өвдөх (10 хүний 3 хүнд), бага зэрэг халуурах (10 хүний 1 хүнд илэрдэг) зэрэг хөнгөн шинж тэмдэг илэрч болно. Эдгээр шинж тэмдгүүд хэдэн цагаас 1-2 өдөр үргэлжилж болно ¹ .	4 WHO (2020) 'Human Papilloma Virus Vaccines and Infertility' ACVS meeting of 4–5 December 2019, in WHO Weekly Epidemiological Record of 24 January 2020, https://www.who.int/groups/global-advisorycommittee-on-vaccine-safety/topics/human-papillomavirus-vaccines/infertility
ХПВ-ийн халдварын эсрэг вакцин үргүйдэлд хүргэдэг	ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь аюулгүй юм. 15 жилийн турш вакцины аюулгүй байдлыг судалсан 160 гаруй судалгаагаар ХПВ-ийн халдварын эсрэг вакцин аюулгүй нь нотлогдсон бөгөөд дархлаажуулалтанд хамрагдсан эмэгтэйчүүдэд үргүйдэлд хүргээгүй байна ³⁻⁷ .	5 Lei, J., Ploner, A., Elfrström et al. (2020) 'HPV Vaccination and the Risk of Invasive Cervical Cancer'. The New England Journal of Medicine 383:1340–1348

ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг нэг тун хийхэд удаан хугацаанд хамгаалж чадахгүй	Нэг тун 4 цэнт ХПВ-ийн халдварын эсрэг вакцины дараах дархлаа удаан хугацаанд хадгалагдах бөгөөд дархлаажуулснаас хойш 10-аас дээш жил эсрэг биеийн титрийн хэмжээ тогтвортой өндөр, 15 жил ХПВ-ийн 16, 18-р хэв шинжийн халдвар, хавдраас хамгаалж байна 8-12.	6 Schmuhi NB, Mooney KE, Zhang X, et al. No association between HPV vaccination and infertility in U.S. females 18-33 years old. <i>Vaccine</i> 2020;38:4038-43 7 Human papilloma virus vaccines and infertility. <i>Weekly epidemiological record</i> . 2017;92(28):393-404
ХПВ-ийн халдварын эсрэг вакцины найрлагадаа эрүүл мэндэд хортой мөнгөн ус агуулдаг	ХПВ-ийн халдварын эсрэг вакцины найрлагад мөнгөн ус агуулагддаггүй ¹³	8 Kreimer AR, Sampson JN, Porras C, et al. Evaluation of durability of a single dose of the bivalent HPV vaccine: The CVT Trial. <i>Journal of the National Cancer Institute</i> 2020;112:1038-46.
ХПВ-ийн халдварын эсрэг вакцины найрлага дахь хөнгөн цагаан маш аюултай	Хөнгөн цагааны давс нь агаар, хүнсний бүтээгдэхүүн, үнэртэй ус, шүдний оо зэрэг гоо сайхны бүтээгдэхүүнд агуулагддагаас гадна хэд хэдэн төрлийн хүүхдийн вакцины найрлагад ордог. Хөнгөн цагааны давсыг 50 гаруй жил олон вакцины үйлдвэрлэлд ашиглаж ирсэн. Вакцин дахь хөнгөн цагааны агууламж маш бага хэмжээтэй байдаг. Хүн өдөр тутмын хоол хүнсээр дамжуулан вакцинтай харьцуулахад 35 дахин их хэмжээний хөнгөн цагааныг авдаг ¹⁴ .	9 Safaeian M, Sampson JN, Pan Y, et al. Durability of protection afforded by fewer doses of the HPV16/18 vaccine: The CVT Trial. <i>Journal of the National Cancer Institute</i> 2018;110:205-12. 10 Safaeian M, Porras C, Pan Y, et al. Durable antibody responses following one dose of the bivalent human papillomavirus L1 virus-like particle vaccine in the Costa Rica Vaccine Trial. <i>Cancer Prevention Research (Philadelphia)</i> 2013;6:1242-50.
ХПВ-ийн халдварын эсрэг вакцин аутизм үүсгэдэг	ХПВ-ийн халдварын эсрэг вакцин бусад вакцины адилаар аутизм үүсгэдэг гэдэг нотолгоо байхгүй байна. Судалгааны үр дүнгээр вакцины найрлага дахь тогтворжуулагч бодис болох хөнгөн цагаан нь аутизм үүсгэх эрсдэлийг нэмэгдүүлдэггүйг тогтоосон ¹⁵ .	11 Sankaranarayanan R, Joshi S, Muwonge R, et al. Can a single dose of human papillomavirus (HPV) vaccine prevent cervical cancer? Early findings from an Indian study. <i>Vaccine</i> 2018;36:4783-91.

ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хямд үнэтэй, хуурамч	ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг манай улс тендерээр бус, НҮБ-ын Хүүхдийн сангийн шугамаар GAVI буюу Вакцин, дархлаажуулалтын глобал альянс байгууллагын бага, дунд орлоготой улс орнуудад олгодог хамгийн хямд үнэ буюу нэг тунг 4,5 ам.доллараар худалдан авдаг ¹⁶ .	12 Malvi SG, Esmy PO, Muwonge et al., A prospective co- hort study comparing efficacy of 1 dose of quadrivalent human papilloma- virus vaccine to 2 and 3 doses at an average follow up of 12 years postvaccination. J Natl Cancer Inst Monogr. 2024 Nov 1;2024(67):317-328. doi: 10.1093/jncimonographs/lgae042. PMID: 39529521; PMCID: PMC11555276.
ХПВ-ийн халдварын эсрэг вакцин амьд вирус агуулдаг тул өвчлүүлдэг	ХПВ-ийн халдварын эсрэг вакцины найрлага дахь вирус төст хэсгүүд нь вирусийн өөрийн генетикийн материал агуулаагүй, зөвхөн ХПВ-ийн уургийн бүрхүүлийг агуулдаг.	13 CDC, https://archive.cdc.gov/www_cdc.gov/vaccine-safety/concerns/thimerosal/index.html
ХПВ-ийн халдварын эсрэг вакциныг манай улсад хийсэн туршлага байхгүй, хүүхдүүдэд туршилт хийгдэж байгаа	Манай улсад энэ вакциныг 2012 онд Улаанбаатар хотын Баянгол, Багануур дүүрэг, Өмнөговь, Сэлэнгэ аймгийн 10 мянга гаруй охидод 3 тунгаар хийсэн. 2022 оноос хойш сайн дурын дархлаажуулалтаар хийж байна.	14 Aluminum adjuvants [website]. Geneva: World Health Organization; 2024. (https://www.who.int/groups/global-advisory-committee-on-vaccine-safety/topics/adjuvants)
Манай оронд өмнө хийгдсэн ХПВ- ийн халдварын эсрэг вакцины үр дүнг судлаагүй	Улаанбаатар хотоос Баянгол, Багануур дүүрэг, Өмнөговь, Сэлэнгэ аймгаас ХПВ-ийн халдварын эсрэг 3 тун вакцинд хамрагдсан 925, ижил насны вакцинд хамрагдаагүй 978 эмэгтэйчүүдийг вакцин хийснээс хойш 5 жилийн дараа дагаж судалсан "Хавдрын Үндэсний Зөвлөл НҮТББ-ын" судалгаагаар 3 тун ХПВ-ийн вакцин ХПВ-ийн өндөр эрсдэлтэй 16-р хэв шинжээс 5 жилийн дараа 90 хувь, 11 жилийн дараа 100 хувь хамгаалсан үр дүн гарсан байна ¹⁷ .	15 ДЭМБ, https://www.who.int/news-room/fact-sheets/detail/autism-spectrum-disorders?gclid=Cj0KCQiAvbm7BhC5ARIsAFjwNHsCDQ80BmwwVu-Visz8Tq3z9dlr5UFEe_DUnBc708Is-60rqbXZ8p2Qa-Aq0ZEALw_wcB 16 https://www.unicef.org/supply/media/20651/file/HPV-vaccine-prices-06022024.pdf 17 Batmunkh T, von Mollendorf C, Tulgaa K, Surenjav U, Dalmau MT, Namjil N, Tsedevdamba B, Tsegmed S, Enkhmaa J, Garland SM, Mulholland K. HPV genoprevalence and HPV knowledge in young women in Mongolia, five years following a pilot 4vHPV vaccination campaign. Papillomavirus Res. 2019 Dec;8:100175. doi: 10.1016/j.pvr.2019.100175. Epub 2019 Jul 2. PMID: 31276802; PMCID: PMC6658929.

Түлхүүр мэдээлэл: Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг нь умайн хүзүүний хорт хавдрын урьдал эмгэг болон хавдрыг эмчлэх боломжтой эрт үед нь илрүүлэх аюулгүй, үр дүнтэй арга

Хүн амын дундах ташаа мэдээлэл	Залруулга мэдээлэл	Эх сурвалж
ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийлгэсэн бол умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт орох шаардлагагүй	ХПВ-ийн халдварын эсрэг вакцин нь умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийг орлохгүй. ХПВ-ийн халдварын эсрэг вакцин хийж буй орнууд хавдрын урьдал эмгэг, хавдрыг илрүүлж эмчлэх зорилготой хүн амд суурилсан умайн хүзүүн хорт хавдар (УХХХ)-ын эрт илрүүлгийн хөтөлбөртэй байх хэрэгцээтэй ¹ .	1 WHO (2022) 'Cervical Cancer'. Fact Sheet https://www.who.int/newsroom/fact-sheets/detail/cervical-cancer
Эмэгтэйчүүдэд ямар нэгэн зовиур байхгүй тохиолдолд эрт илрүүлэгт орох хэрэгцээгүй	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хөтөлбөр нь ямар нэгэн шинж тэмдэггүй, эрүүл эмэгтэйчүүдийн дунд хийгддэг ¹ . Учир нь ХПВ нь урт хугацаанд хүний биед байх боломжтой тул олон жил бэлгийн харьцаанд ороогүй эмэгтэйчүүдэд ч вирус биед нь байж болно. Иймд тогтмол эрт илрүүлэгт хамрагдах нь чухал юм ² . Умайн хүзүүний хорт хавдар оношлогдож буй дундаж нас 53 нас байгаа тул энэ наснаас өмнө эрт илрүүлэгт хамрагдсанаар хавдрыг эрт шатанд нь илрүүлэх магадлалыг нэмэгдүүлдэг ² . Хавдрын эрт шатанд эмчилгээ хийвэл жирэмслэх, төрөх боломжтой.	2 Arbyn, M., Weiderpass, E., Bruni, L. et al. (2020) 'Estimates of Incidence and Mortality of Cervical Cancer in 2018: A Worldwide Analysis'. LancetGlobal Health 8(2): e191–e203. 3 Cancer Research UK (2020) 'Fertility and Cervical Cancer'. https://www.cancerresearchuk.org/about-cancer/cervical-cancer/living-with/fertility
Эрт илрүүлэг үзлэг нь өвддөг бөгөөд эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйд сөрөг нөлөөтэй	Сүүлийн үед ДЭМБ-аас эрт илрүүлэгт ХПВ-ийг илрүүлэх шинжилгээг ашиглах, эмэгтэйчүүд өөрөөсөө үтрээний сорьц авах өвдөлтгүй аргыг ашиглахыг зөвлөж байна ¹ . ХПВ-ийг илрүүлэх шинжилгээг нийт хүн амд 30 наснаас, ХДХВ-ийн халдвартай эмэгтэйчүүдийн дунд 25 наснаас эхлэх ёстой гэж үздэг ¹ .	4 Nohr, B., Krüger Kjaer, S., Soylu, L. and Jensen, A. (2019) 'High-Risk Human Papilloma-virus Infection in Female and Subsequent Risk of Infertility: A Population-Based Cohort Study'. Fertility and Sterility 111(6): 1236–1242.



Боловсруулсан: Б.Цэцэгсайхан, анагаах ухааны доктор, НҮБ-ын Хүн Амын Сангийн зөвлөх

Хянасан: Б.Мөнхзул, Эрүүл Мэндийн Яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын мэргэжилтэн

Б.Цэдмаа, НҮБ-ын Хүн Амын Сангийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөрийн шинжээч

Х.Баттуяа, НҮБ-ын Хүн Амын Сангийн өсвөр үе, залуучуудын мэргэжилтэн

Хоёр дахь хэвлэл.

Хянан тохиолдуулсан: Д.Нарангэрэл, НҮБ-ын Хүүхдийн Сангийн зөвлөх, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан

НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр хэвлэв.